

## СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН

НОМЫН ХУУДСЫГ САНААНДГҮЙ СӨХӨХӨД<sup>1</sup>

Лу Синь

Амрах үедээ өөрийгөө зугаацуулж санаандгүй сөхсөн номын хуудсуудын тухай ярихыг хүсч байна. Учрыг сайн ололгүй ном унших нь хортой ч байж магадгүй юм.

Миний анх ном үзсэн газар гэвэл гэрийн сургууль байлаа. Эхэлж үзсэн ном минь «Зян Ляо»<sup>2</sup> байв. Ширээн дээр минь энэ ном, улаан шугамтай дэвтэр, холбоос уг (энэ нь шүлэг бичихийн баримжаа юм)<sup>3</sup> гэх мэт зүйлээс өөр ямар ч ном байлгахыг зөвшөөрдөггүй байлаа. Гэсэн ч сүүлдээ бага багаар үсэг танидаг боллоо. Үсэг таньдаг болонгуут ном унших сонирхолтой болж билээ.

Манай гэрт уг нь хоёр гурван авдар хуучин уранхай номууд байсан юм. Түүнийг л эргүүлдэг байлаа. Хамгийн гол нь зураг л олж харах санаатай сөхдөг байв. Сүүл сүүлдээ бас үсэгнүүдийг нь хардаг боллоо. Тэгсээр энэ маань зуршил болж, ном л ойрхон харагдаж байвал ямар ч хамаагүй заавал авч эргүүлдэг, эсвэл гарчиглан гүйлгэж харах буюу дотроос нь хэдэн хуудас уншиж орхидог явдал одоо ч гэсэн заншсан хэвээр байна. Зохиол бичсэний дараа юм уу, унших шаардлагатай ном зохиолыг уншиж дууссаны дараа анхаарал сарниж ядарсан цагтаа ингэж зугаа гаргадаг байлаа. Тэгэх нь үнэхээр ядаргааг гаргадаг байв. Хэрэв хүнийг залилая гэвэл ийм аргаар эрдэм соёлтой хүний дүр үзүүлж ч болно.

Одоогийн зарим даруу хүмүүс надтай хууч хөөрсний эцэст намайг их ном уншсан хүн гэлцдэг. Бага сага юм ярихад би үнэхээр их юм уншсан хүн шиг байдаг бололтой. Үүний чухам учир нь гэвэл намайг номын хуудас сөхөж байснаас биш, үнэхээр сэтгэл тавьж нарийн уншаагүй гэдгийг тэд хэрхэн мэдэх ажээ. Бас тэгээд нэг төрлийн төсөөлөхөд хялбар нууц дэвтэр байдаг. Тэр бол «Сыку шу му ти яо» (дөрвөн ангит номын хураангуй) юм. Үүнийг төвөгтэй гэвэл «Цзян Мин му лу» (номын товч гарчиг)-г<sup>4</sup> бас хэлж болно. Үүнийг харин нарийн

харах хэрэгтэй. Тэр чамайг нэлээд их ном уншсан хүн шиг болгож чадна. Тэгэхдээ би ч гэсэн үнэхээр цаг зарцуулж «Го сюе» (хятадын сонгодог сургаал-орч) мэт зохиолыг багшаар удирдуулж бас эрдэмтдийн ашигласан ном зүйн бүртгэлийг анхааралтай хардаг байлаа. Эцэст нь тэр бүхэн хангалтгүй санагдах болов. Зарим номын бүртгэл нь маш их байв. Түүнийг арваад жил уншиж байж дуусгах болохоор зохиогч өөрөө ч бүгдийг уншиж амжаагүй байх гэж эргэлзэх сэтгэл төрдөг байв. Хэдэн сайн номны талаар гарчиг үйлдэж болох юм. Гэхдээ тэр номд гарчиг үйлдсэн эрдэмтэн ямар байхаас шалтгаална. Хэрэв тэр хүн тэнэг бол заасан хэдэн ботийн гарчиг нь мөн л хүний толгойг эргүүлсэн ном болж таарна. Түүнийг уншихгүй байх нь харин ч дээр. Хэрэв унших юм бол толгой эргэнэ. Би энэ дэлхий дээр хойч үеийнхэнд ном сурахад нь удирдах багшгүй гэж хэлж байгаа бишээ. Байх нь ч байна. Гэхдээ түүнийг олоход бэрх юм. Би зөвхөн чөлөөт цагтаа үздэг номын тухай л ярьж байна. Зарим төлөв төвшин нэлээд мэдлэгтэй хүмүүс ингэвэл «холимог» болно гэж эсэргүүцэх юм. «Холимог» гэдэг одоогоор нэлээд муу хавсарга нэр үгэнд тооцогдож байна. Гэвч би үүнийг бас сайн талтай гэж үзнэ. Жишээ нь нэг айлын хуучин дансыг үзэхэд өдөр болгон «3 мөнгөний тофу, 10 мөнгөний ногоо, 50 мөнгөний загас, 1 мөнгөний жан» гэж тэмдэглэснээр бид эрт урьд цагт ийм хэдхэн мөнгөөр нэг өдрийн зууш авч нэг өрх айлыг цатгаж байсныг ойлгож болох юм. Эртний төлгийн номонд «гадагш явж үл болно, биеэ угааж үл болно, өдөр судар үзэлгүй байшин босгож үл болно» гэсэн байдаг. Үүнээс бид урьд цагт хориотой зүйл олон байсныг мэдэж болох юм.

Сун улсын хуний тэмдэглэл харахад «Шицай ши-мо»<sup>5</sup> (ногоо идвэл хэрэг үйлсэд саадтай, ор.) гэж байдаг.

<sup>1</sup>Энэ өгүүлэл анх 1934 оны 11-р сард «Дүшүшэи хуо» хэмээх сарын сэтгүүлийн I ботийн 2-т нийтлэгдэв. 107-р тал. Монгол хэлнээ анх удаа хэвлэгдэж байна.

<sup>2</sup>«Булш» «Дэн доорхи тэмдэглэлийн» зүүлт 5, 107 дугаар тал.

<sup>3</sup>«Нахан», «Кун И Зи»-гийн зүүлт 2-ийг үзнэ үү.

<sup>4</sup>«Дөрвөн төрлийн бүрэн зохиолын ерөнхий программ». «Цзян Мин Му Лу» гэдэг бол дээрх ерөнхий программыг товчилсон гарчиг.

<sup>5</sup>Сун улсын үеийн одоогийн сургаалын нэгэн булгийн номлол.

<sup>6</sup>«10 бамбар, 5 бар»-ыг «5 бамбар 5 бар» болгон залруулах хэрэгтэй.

Мин улсын хүний тэмдэглэлд «10 бамбар, 5 бар»<sup>6</sup> гэж байдгийг хараад

<sup>1</sup>Энэ өгүүлэл анх 1934 оны 11-р сард «Дүшүшэи хуо» хэмээх сарын сэтгүүлийн I ботийн 2-т нийтлэгдэв. 107-р тал. Монгол хэлнээ анх удаа хэвлэгдэж байна.

<sup>2</sup>«Булш» «Дэн доорхи тэмдэглэлийн» зүүлт 5, 107 дугаар тал.

<sup>3</sup>«Нахан», «Кун И Зи»-гийн зүүлт 2-ийг үзнэ үү.

<sup>4</sup>«Дөрвөн төрлийн бүрэн зохиолын ерөнхий программ». «Цзян Мин Му Лу» гэдэг бол дээрх ерөнхий программыг товчилсон гарчиг.

<sup>5</sup>Сун улсын үеийн одоогийн сургаалын нэгэн булгийн номлол,

<sup>6</sup>«10 бамбар, 5 бар»-ыг «5 бамбар 5 бар» болгон залруулах хэрэгтэй.

«эрт дээр цагт ийм амьтад бас байж» гэдгийг ойлгож болох юм. Зарим боть номыг дуустал уншихад тухайн үеийн нэрт хүмүүсийн тухай тэмдэглэхдээ нэг жанжин 38 аяга хоол нэг доор идэж орхидог байсан тухай, нэг хүний биеийн хүнд 175 жин хагас байсан гэх зэргээр бичсэн байдаг. Тэрчилэн нэг тосгонд хувилсан жаран хөлт хорхойг аянга ниргэв. Нэг эхнэр, хүн толгойтой могой төрүүлсэн гэх мэт ямар ч ашиггүй зүйл ч байдаг. Ийм үед өөрийн гэсэн бодолтой байх хэрэгтэй. Тэдгээр номыг хоол хороогч мэргэд бичсэн болохыг мэдэх нь чухал. Хоол хороогч мэргэдүүд хүний цагийг ямар ч үр ашиггүй өнгөрөөх хамгийн бүтэлгүй аргыг хэрэглэдэг. Хэрэв болгоомжлохгүй бол түүнд хөтлөгдөн гүнзгий хонгилд ойчиж, хожим нэг жанжны идсэн хоолны хэмжээ, нэг эрхмийн биеийн хүндийн жин хувилсан жаран хөлт хорхой, хүн толгойтой могой зэрэг ямар ч хэрэггүй зүйлээр толгой чинь дүүрсэн байх бий.

Зарим үед мэрэг төлөг, янхны тухай ном ч тохиолдож болох юм. Тэгвэл хөмсөг зангидан дургүйцэх байдал гаргалгүй сөхөж бас болно. Заримдаа өөрийн бодлын эсрэг, үеэ өнгөрөөсөн ном гэдгийг мэдсээр байж мөн л адилхан арга хэрэглэнэ. Жишээ нь Ян ноёны «аргагүйн эрхэнд»<sup>7</sup> ном Чин улсын эхэн үед зохиогдсон боловч уншихад үзэл санаа нь амьд хэвээр байх бөгөөд одоо яг түүнтэй ижил төстэй бодол санаатай хүмүүс нэлээд байна. Түүний нөлөөнд автаж болох учраас энэ бас бага зэрэг аюултай. Түүнийг засах арга гэвэл ном л их сөхөх хэрэгтэй. Сөхсөөр сөхсөөр их сөхөөд ирэхлээр харьцуулж болно. Харьцуулна гэдэг бол мэхлэгдсэнийг засдаг сайн арга. Хөдөө тосгоны хүн галтмар зэсийг алт гэж эндүүрдэг. Тэдэнд зүгээр хэлж өгөхөд ойлгохгүй, эрдэнийн зүйлсийг залилаад зүгээр авчих гээд байна гэж бодоод түүнийгээ бушуухан нуучихдаг. Хэрэв тэр жинхэнэ ши-жир алтыг алган дээрээ тавьж үзвэл сая 'учрыг сайтар ойлгож итгэнэ.

«Номын хуудсыг санаандгүй сөхөх» нь янз бүрийн эрдэнэсийн чулууг хооронд нь харьцуулж байгаа арга учраас маш төвөгтэй ажил

юм. Жинхэнэ алттай жишиж ойлгодог шиг тодорхой бөгөөд товчхон арга биш. Одоогийн залуучуудыг харж байхад ямар ном унших тухайгаа хүнээс дандаа асууж байдаг нь жинхэнэ алтыг л олж харах, галтмар зэсэнд хууртахгүй гэсэн хэрэг юм. Тэд нэгэнт шижир алтыг таниж авбал дараа нь галтмар зэсийг ч андахгүй танидаг болох учир нэгэн сумаар хоёр туулайг буудна гэсэн хэрэг болно.

Гэтэл хятэдын одоогийн ном зохиолоос иймэрхүү сайхан зүйлийг тийм ч амар олж авахгүй. Би их л зовж байж өчүүхэн мэдлэг олж авсныгаа цаг ямагт эрэгцүүлэн боддог «Анхны хүн тэнгэр, газрыг нээсэн» тэр цагаас хойш хятад улс гурван тэнгэр, 5 хаантай болж...Сун, Юан, Мин «манай их Чин»<sup>8</sup> улстай байсан гэж би хүүхэд ахуйдаа мэдэх болсон юм. 20 настай байхдаа «манай Чингис хаан»<sup>9</sup> европыг довтолсон нь «Бидний» хээнцэр ид хав болсон гэж сонссон юм. 25 настайдаа тэрхүү «Бидний» хээнцэр ид хав гэдэг нь үнэн хэрэг дээр Монголчууд Хятадыг байлдан дагуулаад бид боол нь болсон явдал гэдгийг сая ухаарч билээ. Түүнээс хойш энэ оны наймдугаар сард би өнгөрсөн үеийн нэгэн баримт олохын тулд монголын түүхэнд холбогдолтой гурван ном эргүүлж байж монголчууд «Оросыг» байлдан дагуулж,<sup>10</sup> Унгарт түрэмгийлэн орсон нь бүх хятадыг байлдан дагуулахаас бүр өмнө болсон хэрэг гэдгийг сая ойлгов. Тэр үеийн Чингис хаан, манж хаан ч бас байгаагүй, харин Оросуудын боолчлогдсон хугацаа нь биднээс эрт байсан болохоор тэд харин «манай Чингис хаан хятадыг байлдан дагуулсан явдал бол бидний хээнцэр ид хав байлаа» гэж хэлж болох байжээ.

Би одоо манайд хэрэглэж байгаа түүхийн сурах бичгийг үзэлгүй нэлээд удсан учир түүнд энэ тухай хэрхэн өгүүлж буйг сайн мэдэхгүй байна. Харин сонин сэтгүүлд Чингис хааны баатар зоригийг өөрийн болгож бахархан бичсэн өгүүллүүд заримдаа харагдах болжээ. Хэрэг явдал аль эрт өнгөрсөн болохоор нэг талаар төдийлөн ач холбогдолгүй байж болох боловч нөгөө

<sup>7</sup> «Булш». «Толинд харсан сэтгэгдэл»-ийн зүүлт 7-г үз.

<sup>8</sup> «Манай их Чин улс» гэдэг үг тухайн үед ихээхэн дэлгэрч байсан «Сан Зы Зинь» (гурван усгийн номлол) хэмээх сударт байдаг үг. Ансингёро хятадыг эзэлснээс хойш Хан үндэстний түшмэлүүд харь үндэстэн Чин улсын засгийн газрыг тийнхүү манай их Чин улс гэж нэрлэж байсныг Лу Синь энд зориуд ёжилсон утгаар хэлж буй 109-р тал.

<sup>9</sup> «Сянь Сянь Зи», «Манай улс Оросыг довтлон байлдсан нэгэн хуудас»-ыг хар.

<sup>10</sup> Чин улсын Хун Зюн. «Юан улсын түүхийн орчуулсан үгсийн нөхөн тайлбарлах нь» 26-р боть. «Синь Юаньши»- 257-р тал.

талаар бүр ч их ач холбогдолтой мэт байж ч болох юм. Ямар ч атугай үнэн мөнийг л хэлэх нь дээр байх.

Миний бодлоор бол утга зохиолыг судлаачид ч байг, шинжлэх ухааныг ч судлаачид байг эхлээд тэр түүхийн талаархи товч бөгөөд найдвартай нэгэн боть номыг эрхбиш уншсан байх хэрэгтэй. Хэрэв нэг хүн зөвхөн уран (хүдэр-орч) од гариг, хавч хорхойн мэдэрлийн эсийг яриад байх юм уу, эсвэл зөвхөн гүйлсэн цэцгийн тухай шүлэг бичдэг бөгөөд эмэгтэй дүүгээ нийгмийн тухай маргуулах дургүй хүн байвал тэр түүхийн номыг уншихгүй байсан ч болох л юм.

Миний хувьд гэвэл япон бичиг бага зэрэг мэдэх учир «Дэлхийн түүхийн сурах хөтөлбөр», бас шинэ гарсан «Хятадын нийгмийн түүх»<sup>11</sup> зэрэг япон хэлнээ хөрвүүлсэн эхийг уншиж үзлээ. Энэ нь миний урьд уншсан түүхийн номыг бодвол нэлээд тодорхой бичигджээ. Түүрүүнд дурдсан номын эхний ганцхан дэвтрийг

хятадаар орчуулжээ. Сүүлийн 5 дэвтрийг орчуулаагүй. Тэр номыг олж хараагүй учир хэр зэрэг орчуулсныг мэдэхгүй. Харин сүүлийн номыг Хятадад орчуулсан эх бий бөгөөд түүнийг «Хятадын нийгмийн түүх» гэдэг. Гэхдээ япон хэлнээ хөрвүүлсэн хүний хэлснээр бол тэр номонд алдаа ташаа эүйл их, хасч товчилсон тал ч байгаа болохоор найдваргүй гэнэ.

Би Хятадад тэр хоёр ном байдаг болоосой гэж хүссээр байна. Бас «ухас» гээд цугларч, «ухас» гээд тарахыг хүсэхгүй байна. Орчуулбал дуусгах хэрэгтэй. Хасч товчлохгүй байхын дээр хэрэв хасч товчилбол түүнийгээ уншигчдад мэдэгдэх хэрэгтэй. Ямар ч гэсэн нягт нямбай хичээнгүйлэн, бүрэн бүтнээр нь орчуулж зохиогчид ба уншигчдынхаа төлөө санаа тавих хэрэгтэй юм.

Лу Синь бүрэн зохиолын эмтхэтгэл VI боть 107—110-р тал.Хятад хэлнээс орчуулсан **Ц. Хандсүрэн**

<sup>11</sup> Оросын Ж. М. Бочаров нарын зохиосон «Дэлхийн түүхийг сурах бичгийн программ» «Тэргүүн дэвтэр нь «Феодалын нийгмийн түүх» Сю Луниин нар орчуулав. 1934 он. Г. Л. Сафаров «Хятадын түүхийн сэдвүүд» гэдгийг «Хятадын нийгмийн хөгжлийн түүх» хэмээх нэртэй 1932 онд нийтэлжээ.